



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, ЭМС-ын 2025 оны А/219 тоот тушаал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан ба ЭХЭМҮТ-ийн 2023-2027 онд хамтран ажиллах гэрээ, 2026 онд хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2026 оны төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан “Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт хариу арга хэмжээний сургалт” зохион байгуулах арга хэмжээний ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Баттулга /Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал/

Нарийн бичгийн дарга: Э.Хүслэн /НҮЭМ-ийн тусламж үйлчилгэний зохицуулагч/

Гишүүд: М.Жавхлан /Ахлах нягтлан бодогч/
Б.Нямбадам /ТССА-ны эмч/
П.Орхонтуул /ТССА-ны ажилтан/

2. Тус үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсвийг ЭХЭМҮТ-ийн захирлын 2026 оны 02 сарын 26-ны А36 тоот зардал гаргах тухай тушаалын дагуу ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд олгохыг Ахлах нягтлан бодогч /М.Жавхлан/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Г.Баттулга), Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал (Э.Бямбасүрэн) нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.ОТГОНБААТАР

160606-171